

Хязгаарлагдмал орчинд ажиллах аюулгүй ажиллагааны заавар

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү заавар нь ажилтан хязгаарлагдмал орчинд нэвтрэх эсвэл ажиллах үед тэдний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах зорилготой.
- 1.2 Энэхүү зааврыг боловсруулахад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсгийг үндэслэл болгов.
- 1.3 Энэхүү зааврыг хязгаарлагдмал орчин бүхий ажлын байртай ажил олгогч мөрдөнө.

Хоёр. Тодорхойлолт

2.1 Хязгаарлагдмал орчин (ХО)

Хүн байнга ажиллахад зориулагдаагүй хагас эсвэл бүтэн хаалттай орчныг хэлнэ. ХО-нд дараах шаардлагыг хангасан тасалгаа, шингэн болон хуурай материал хадгалах нөөцлүүр сав, худаг (траншей), тогоо, хоолой, утаа, агаар дамжуулах яндан хоолой, бусад төрлийн орчин хамаарна. Хязгаарлагдмал орчин нь ажилтанд дараах эрсдэлийг бий болгоно.

- а) Ажилтанд хордлого үүсгэх, галын эсвэл тэсэрч дэлбэрэх аюултай, хортой химийн бодисын хий, уур, тоосонцор агуулагдах;
- б) Хүн хэвийн амьсгалахад сөргөөр нөлөөлөх эсвэл агааржуулалт хангалтгүйн улмаас амьсгалын дутагдалд хүргэх;
- с) Ажилтныг ажиллах үед живүүлэх эсвэл сорох аюултай материал агуулсан.

2.2 Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан (ХОААХА)

Зааврын 5-д заасны дагуу чадамжтай ажилтнуудад хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөл олгох, хяналт тавих, ХО-ны аюулгүй ажиллагааг ерөнхийд нь хариуцах үүрэгтэй ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан.

2.3 Чадамжтай ажилтан

Хязгаарлагдмал орчинд ажил гүйцэтгэхэд шаардлагатай туршлага хуримтлуулж, зохих сургалтад хамрагдсан ажилтан.

2.4 Хязгаарлагдмал орчинд ажиллах дагалдан ажилтан

Зааврын 6.4-т заасны дагуу томилогдсон ХО-нд ажиллах ажилтныг дагалдаж, аюулгүй байдалд ажиглалт хийх, тусалцаа үзүүлэх, шаардлагатай нөхцөлд онцгой үеийн бэлэн байдлын төлөвлөгөө хэрэгжүүлэх ажилтан.

2.5 Хязгаарлагдмал орчин хариуцсан эрх бүхий ажилтан

Нэвтрэх, ажил гүйцэтгэх ХО-ны эзэмшигч байгууллагыг төлөөлөн томилогдсон эрх бүхий ажилтан.

2.6 Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөл

Зааврын 5-д заасны дагуу ХО-нд нэвтрэх ажилтанд олгох зөвшөөрөл.

2.7 Хязгаарлагдмал орчинд нэвтрэх

Зөвшөөрлийн дагуу ажилтны толгой эсвэл бүх бие ХО-нд орохыг хэлнэ.

2.8 Аюултай орчин

Ажилтны амь нас, эрүүл мэндэд аюул учруулах эрсдэлтэй дараах орчин хамаарна:

- a) Агаарт агуулагдах хүчилтөрөгчийн 19.5-23.5% -ээс их эсвэл бага;
- b) Агаарт агуулагдах шатамхай хий, уурын түвшин 10% эсвэл тэдгээрийн тэсрэх доод хязгаараас нь хэтэрсэн;
- c) Агаар дахь хорт бодисын хэмжээ MNS 4990 стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн.

Гурав. Ерөнхий шаардлага

4.1 Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан

- 4.1.1 Аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан нь “Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан” (ХОААХА) байна.
- 4.1.2 ХОААХА нь энэхүү зааврыг хэрэгжилтийг хариуцаж, бусад холбогдох талуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 4.1.3 Аж ахуйн нэгж байгууллага нь ХОААХА хариуцсан ажилтнаа ХО-ны агаарын чанарын хэмжилт хийх шаардлага хангасан багажаар хангаж, шалгалт тохируулгыг 3-6 сар тутамд хийлгэнэ.
- 4.1.4 ХАБЭА-н ажилтангүй жижиг аж ахуйн нэгж, байгууллага зохих шалгуур хангасан мэргэжлийн байгууллагаар тохируулгыг хийлгэнэ.

4.2 Хязгаарлагдмал орчинтой ажлын байрны бүртгэл

- 4.2.1 Аж ахуйн нэгж байгууллага нь өөрийн эзэмшлийн эсвэл түр ашигладаг барилга байгууламж, дэд бүтцэд хамаарах байнгын ХО-ныг нэг бүрчлэн тодорхойлж, бүртгэнэ.
- 4.2.1 Бүртгэлд ХО-ны тодорхойлолт, байрлалыг тэмдэглэнэ.
- 4.2.2 Ажил үүргийнхээ явцад ХО-ны аюулд өртдөг эсвэл өртөж болзошгүй ажилтнуудад энэ талаар мэдээлнэ.
- 4.1.3 ХО-ны тоог хамгийн боломжтой хэмжээнд цөөлнө.

4.3 Хязгаарлагдмал орчны орц, гарцны аюулгүй байдал

- 4.3.1 Барилга байгууламж эзэмшигч эсвэл түр ашиглагч нь аливаа ХО-ны орц, гарцыг ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндэд эрсдэл учруулахгүй байхаар төлөвлөж, зохих урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.4 Хязгаарлагдмал орчны тагыг нээх

- 4.3.1 ХО-ны агаарт гадаад орчныхоос их даралттай хортой, аюултай бодис хуримтлагдаж болзошгүй тул ажилтан нэвтрэхээс өмнө хордлого, осол, гэмтлээс урьдчилан сэргийлж, дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - a) ХО-ны даралтыг тэнцвэржүүлж, нээх үед хорт бодис чөлөөлөгдөхөөс /уурших, тархахаас/ сэргийлж аюулгүй болгосны дараа нэвтрэх тагийг авах;
 - b) Тагийг авах үед ХО-ны нээлттэй хэсгийн эргэн тойронд хаалт, хашилт, тэмдэг, тэмдэглэгээ бусад үр нөлөөтэй хамгаалалтыг хийж хүн, эд зүйл унахаас сэргийлнэ.
- 4.3.2 ХО-ны тагийг нээх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан биечлэн хяналт тавина.

4.5 Хязгаарлагдмал орчны гэрэлтүүлэг

4.5.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан нь ХО-нд ажилтан нэвтрэх, ажиллах үед тухайн орчны гэрэлтүүлгийг хангалттай, тохиромжтой байлгах үүрэг хүлээнэ.

4.6 Хязгаарлагдмал орчны агааржуулалт

4.6.1 ХО-нд ажилтан нэвтрэх, ажиллах үед тухайн орчны агааржуулалт нь ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхээргүй байхаар төлөвлөнө.

4.6.2 ХО-нд ажилтан нэвтрэх, ажиллахад зориулж хангалттай, үр нөлөөтэй зөөврийн эсвэл суурин механик агааржуулалтыг ашиглана.

4.6.3 Агаараар хангах агааржуулалт нь :

а) Аливаа бохирдолгүй;

б) ХО дахь ажилтны байрлаж буй талбай руу агаарын урсгал чиглэнэ.

4.6.4 Сорох агааржуулалт нь сорсон агаараа ХО-ны гадна тал руу, бусад ажилтнууд, ойр орчмын оршин суугчидад аюулгүй байдлаар зайлуулна.

Тав. Хязгаарлагдмал орчинд нэвтрэхэд тавих хяналт

5.1 Хязгаарлагдмал орчинд нэвтрэх ажилтанд тавигдах шаардлага

5.1.1 ХО-нд нэвтрэх ажилтан нь ХО-нд ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадварыг эзэмшиж, зохих туршлагыг хуримтлуулсан байна.

5.1.2 ХО-нд нэвтрэх ажилтан нь ХАБЭА-н тусгай сургалтад хамрагдаж, зохих шалгуурыг хангасан, өөрийн болон бусдын аюулгүй байдал, эрүүл мэндэд эрсдэл учруулахгүйгээр ажил үүргээ гүйцэтгэх дадлыг эзэмшсэн байна.

5.1.3 ХО-нд нэвтрэх ажилтан нь эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж, зохих шалгуурыг хангасан байна.

5.1.4 Зөвхөн “Хязгаарлагдах орчинд нэвтрэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй” ажилтан ХО-нд нэвтрэнэ.

5.1.5 ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан нь ХО-нд нэвтрэх ажилтанд зөвшөөрөл олгохоос өмнө дараах байдлаар хяналт тавьж, шаардлага хангаж буй эсэхийг нягтална. Үүнд:

а) Нэвтрэх ажилтан нь ХО-нд үндсэн ажил үүргээ гүйцэтгэх “Чадамжтай ажилтан” болохыг тухай ажилтны удирдах албан тушаалтны зөвшөөрөл, ажлын туршлагад үндэслэн тодорхойлно.

б) Нэвтрэх ажилтан нь ХО-нд аюулгүй ажиллах “Чадамжтай ажилтан” болохыг ХАБЭА-н дүрэм журмын дагуу тусгай сургалтанд хамрагдсан байдлаар тодорхойлно.

5.2 Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрлийн маягт

5.2.1 ХО-нд нэвтрэх зөвшөөрлийн маягт нь Хавсралт 1-д заасан агуулгатай байна.

5.2.2 Ажлын байрны онцлогоос хамаарч зөвшөөрлийн маягтад нэмэлт мэдээлэл оруулж болно.

5.2.3 Ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг нэвтрэх зөвшөөрөлд тусгана.

5.3 Агаарын чанарын хэмжилт хийгдээгүй болон зөвшөөрөлгүй ХО-нд нэвтрэх

5.3.1 Дараахиаас бусад нөхцөлд ХО-нд аливаа хүн нэвтрэх эсвэл ажиллахыг хориглоно.

- a) ХО бүхий ажлын байрны эзэмшигч нь үнэлгээ хийх зорилгоор нэвтрэх; болно.
 - b) ХО-нд нэвтрэх зөвшөөрөл нь зөвхөн үнэлгээ хийхэд хүчинтэй.
- 5.3.2 Зааврын 5.3.1 заалтын дагуу ХО-нд нэвтрэх хүн дараахь шаардлагыг хангасан байна.
- a) Стандарт шаардлага хангасан амьсгалын аппаратыг зүүнэ.
 - b) ХО-ныг хариуцсан удирдах албан тушаалтнаас нэвтрэх зөвшөөрөл авна.
 - c) Аюулгүйн бэхэлгээтэй өндрийн бүс зүүх эсвэл тохиромжтой хамгаалах хэрэгслээр тоноглогдсон байна. ХО-нд ажиллах дагалдан ажилтан гадна талд байрлаж, онцгой нөхцөлд ажилтныг татаж гаргах эсвэл аврах ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

5.4 Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөл, хүсэлт

- 5.4.1 ХО-нд нэвтрэх зөвшөөрлийг дэс дарааллаар олгоно.
- a) ХО-нд нэвтрэх, ажил гүйцэтгэх шаардлагатай нэгжийн ахлах ажилтан, Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтанд зөвшөөрлийн хүсэлт гаргана.
 - b) Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан нь “Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрлийн маягт”-ыг 3 хувь бөглөнө.
 - c) Зөвшөөрлийн маягтад нэвтрэх ХО-нд хийсэн агаарын чанарын хэмжилтийн дүн, зайлшгүй тохиолдолд авах аюулгүй ажиллагааны хяналтын арга хэмжээг бичнэ.
 - d) Бөглөсөн зөвшөөрлийн маягтыг нэвтрэх, ажил гүйцэтгэх ХО-ныг хариуцсан эрх бүхий ажилтнаар хянуулж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 5.4.2 ХО-нд ажилтан нэвтрэхээс өмнө агаарын чанарын хэмжилт хийнэ. Агаарын чанарын хэмжилт нь зөвхөн тухайн өдрөө хүчинтэй.
- 5.4.3 ХО-ны агаарын чанарын хэмжилт хийхэд:
- a) Шалгалт тохируулга хийлгэсэн, тохирсон багажийг ашиглана.
 - b) Хэмжилтийг гүйцэтгэх дэс дараалал:
 - I. Хүчилтөрөгчийн агууламж;
 - II. Шатамхай хий эсвэл уурны агууламж;
 - III. Тухай орчинд ач холбогдолтой хорт хийн концентраци;
 - c) Хэмжилт хийх ажилтан нь өөртөө болон бусдад аюул учруулахгүй байхад анхаарна.
 - d) Хэмжилтийн үр дүнг зөвшөөрлийн маягтад заавал тэмдэглэнэ.
- 5.4.4 Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан нь тухайн ажилтныг ХО-нд нэвтрэхэд аюулгүй байдал, эрүүл мэндийн хувьд шаардлага хангасан гэж дүгнэвэл зөвшөөрөлд гарын үсэг зурж, ХО хариуцсан эрх бүхий албан тушаалтнаар хянуулна.
- 5.4.5 Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан нь хэмжилт, үнэлгээ хийх, зөвшөөрөл олгох ажил үүргээ нягт нямбай, хариуцлагатай гүйцэтгэнэ.

5.5 Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрөл олгох

- 5.5.1 Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан нь дараахь шаардлагыг хангасан тохиолдолд ХО-нд ажиллах ажилтанд нэвтрэх зөвшөөрлийг олгоно.
- a) Агаарт агуулагдах хүчилтөрөгчийн түвшин 19.5-23.5%-ийн хооронд байх;
 - b) Агаарт агуулагдах шатамхай хий, уурны түвшин 10% эсвэл тэдгээрийн тэсрэх доод хязгаараас нь бага;
 - c) Агаар дахь хорт бодисын хэмжээ MNS 4990 стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй;

- d) ХО нь хангалттай агааржуулалттай;
 - e) ХО-нд нэвтрэх үед ажилтанд аюултай хий, уур, хорт бодисын дэгдэлтэд өртөхөөс сэргийлсэн үр нөлөөтэй арга хэмжээг хэрэгжүүлсэн,
 - f) ХО-нд нэвтрэх ажилтан шаардлага хангасан ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон;
 - g) ХО-нд нэвтрэх ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн ач холбогдол бүхий зохих арга хэмжээг хэрэгжүүлсэн.
- 5.5.2 Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан нь нэвтрэх зөвшөөрлийн 1 хувийг хүсэлт гаргасан ахлах ажилтанд, 1 хувийг ХО хариуцсан эрх бүхий албан тушаалтанд тус тус өгч, 1 хувийг өөртөө хадгална.
- 5.5.3 ХО хариуцсан эрх бүхий албан тушаалтан нь зөвшөөрөл олгохтой холбоотой ажилд нягт нямбай, хариуцлагатай хандана.
- 5.5.4 ХО-нд нэвтрэх зөвшөөрлийг хүчинтэй хугацаанд ашиглаагүй бол, зааврын 5.4-т заасны дагуу дахин нэвтрэх зөвшөөрөл авна.
- 5.6. Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрлийг мэдээлэх**
- 5.6.1 ХО-нд нэвтрэх зөвшөөрлийг хүлээн авах ахлах ажилтан нь дараах үүрэгтэй.
- a) Зөвшөөрлийн хуулбарыг ажил гүйцэтгэх талбайн бүдүүвч зургийн хамт ХО-ны орох хэсэгт байрлуулна.
 - b) Зөвшөөрлийн хуулбарыг дараах хугацаа хүртэл авч болохгүй.
 - I. Зөвшөөрлийн хугацаа дуусах огноо;
 - II. Зөвшөөрлийг солих;
 - III. ХО-д нэвтэрсэн ажилтан ажлаа гүйцэтгэж дуусаад гарах хүртэл.
- 5.7 Хязгаарлагдмал орчинд ажиллах ажилтанд аюулгүй байдлын мониторинг хийх**
- 5.7.1 ХО-нд ажиллаж буй ажилтны аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах зайлшгүй шаардлагатай арга хэмжээг ажил гүйцэтгэх хугацааны турш хэрэгжүүлэхэд ахлах ажилтан, хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан хамтран хяналт тавьж ажиллана.
- 5.7.2 ХО-ны гадна талд дагалдах ажилтан байрлаж, тохиромжтой хэлбэрээр ажил гүйцэтгэж буй ажилтантай байнгын холбоотой байж, хяналт тавьж, шаардлагатай нөхцөлд онцгой үеийн бэлэн байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
- 5.7.3 Ажилтан ХО дахь ажлаа гүйцэтгэж дуусаад гарсан талаарх мэдэгдлийг ахлах ажилтнаас хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан болон ХО хариуцсан эрх бүхий албан тушаалтанд мэдээлнэ.
- 5.8 Агаарын чанарын явцын хэмжилт**
- 5.8.1 Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан нь ХО-нд ажилтан нэвтэрсэн эсвэл ажил гүйцэтгэж буй орчны агаарын чанарт хяналт тавихдаа дараах шаардлагыг биелүүлнэ.
- a) 45 минутаас удаан хугацаад ХО-нд ажил гүйцэтгэх тохиолдолд агаарын чанарын хэмжилтийг давтамжтай хийж, хяналт тавих;
 - b) ХО-нд 2 ба түүнээс олон хүн ажиллаж байгаа бол тэдэнд агаарын чанарын тогтмол мониторингийн багаж (газ детектор)-ийг зүүлгэнэ. Мониторингийн багаж нь тухайн орчинд үүсэх хийг хэмжих зориулалттай байна.

с) Дээрх 2 төрлийн хэмжилтийн аль нэгний үр дүнгээр аюултай нөхцөл тодорхойлогдвол:

- I. Гүйцэтгэж буй ажлыг зогсоож, ХО дахь бүх ажилтныг нэн даруй гаргах;
- II. Аюултай нөхцөл байдал хэрхэн үүссэн талаарх үнэлгээг хийх;
- III. ХО-нд нэвтрэх зөвшөөрлийг эрх бүхий удирдах ажилтан дахин олгох хүртэл ямар ч ажилтан дахин орохгүй.

5.8.2 Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан нь 5.8.1(а)-д заасан хэмжилтийн үр дүнг ХО-нд нэвтрэх зөвшөөрлийн маягтад тэмдэглэнэ.

5.8.3 Бөглөсөн зөвшөөрлийн маягтыг 2 жилээс багагүй хугацаагаар хадгална.

5.9 Үл тохиролтой ажлыг мэдээлэх үүрэг

5.9.1 ХО бүхий ажлын байранд ажил үүрэг гүйцэтгэх үед үл тохирлыг ажиглаж мэдсэн хэн боловч уг ажлыг хариуцсан ахлах ажилтан, ХОААХА, ХО хариуцсан эрх бүхий албан тушаалтны хэн нэгэнд нэн даруй мэдээлнэ.

5.9.2 Үл тохиролтой ажил гэдэг нь ХО-нд ажил гүйцэтгэж буй ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй ажлыг хэлнэ.

5.10 Хязгаарлагдмал орчинд нэвтрэх зөвшөөрлийг хянах, зөөн шилжүүлэх

5.10.1 ХО хариуцсан эрх бүхий албан тушаалтан нь ХО-нд нэвтрэх зөвшөөрлийг өдөр тутам хянаж, тохиромжтой байдлыг нь үнэлнэ.

5.10.2 ХО-нд нэвтрэх зөвшөөрлийг олгосны дараа ХО-нд ажиллаж буй ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тэдгээр ажилтныг гаргаж, нэвтрэх зөвшөөрлийг хүчингүй болгоно.

5.10.3 ХО хариуцсан эрх бүхий удирдах ажилтан нь зааврын 5.10.2-т заасныг тооцохгүйгээр дараах эрхтэй:

а) Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд ХО-нд нэвтрэх зөвшөөрлийг хүчингүй болгоно:

- I. ХО-нд гүйцэтгэх ажил нь бүрэн хэрэгжиж дууссан;
- II. ХО-нд хийж гүйцэтгэх ажлыг заасан хугацааны турш үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй;

б) Зааврын 5.8.1(с)-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд ХО-нд нэвтрэх зөвшөөрлийг тус тус хүчингүй болгоно.

Зургаа. Бусад зүйл

6.1 Анхааруулах тэмдэг

ХО бүхий аливаа ажлын байр эзэмшигч нь ХО-нд нэвтрэх хэсэгт аюулыг анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээг зөвшөөрөлгүй хүмүүс, иргэдэд зориулж ойлгомжтой, харагдахуйц байдлаар байршуулна.

6.2 Ажилтны нэр, үнэмлэхийг шалгах

Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан нь ХО-нд нэвтрэх ажилтны нэр, үнэмлэхийг нэвтрэх зөвшөөрлийн маягтын мэдээлэлтэй нэг бүрчлэн тулгаж шалгана.

6.3 Ажилтны сургалт

6.3.1 Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан нь ХО-нд нэвтрэх, ажиллах ажилтанд ХО-ноос үүсэх аюул, ХАБЭА-н тусгай сургалтад хамрагдаж хангалттай түвшний мэдлэг, дадлыг эзэмшсэн байх нөхцөлийг бүрдүүлнэ.

6.3.2 Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан нь ХО-нд нэвтрэх, ажиллах ажилтныг үндсэн ажил үүргээ аюулгүй гүйцэтгэх чадамжтай эсэхэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд давтан сургалтад хамруулах үүрэгтэй.

6.4 Хязгаарлагдмал орчны дагалдах ажилтан

6.4.1 Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан нь ХО-нд ажилтан нэвтрэхээс өмнө дагалдан ажилтныг томилно.

6.4.2 ХО-нд ажиллах дагалдан ажилтан нь дараах үүрэгтэйгээр ХО-ны гадна талд үлдэнэ.

- a) ХО-нд нэвтэрсэн ажилтанд хяналт тавих;
- b) ХО-нд ажиллаж буй ажилтантай тогтмол харилцаатай байж, шаардлагатай үед ХО-ноос гарахад нь туслах;
- c) Гадаад орчинд бий болох онцгой нөхцөлийн үед ХО-нд ажиллаж буй ажилтанд мэдээлж, гарахад туслах;
- d) Ослын үед онцгой үеийн бэлэн байдлын төлөвлөгөө хэрэгжүүлнэ.

6.5 Аврах ажиллагаа

6.5.1 ХО-нд нэвтэрсэн ажилтныг хариуцсан хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан нь дараах үүрэгтэй:

- a) Онцгой нөхцөлд ХО-нд ажиллаж буй ажилтныг аврах бичгээр үйлдсэн төлөвлөгөөтэй байх;
- b) Анхны тусламж, хувийн хамгаалах хэрэгсэл, ХО-нд аврах ажиллагаа явуулахад шаардлагатай бусад багаж, хэрэгслийг ашиглах зэрэг агуулгыг багтаасан сургалтад хамрагдаж, зохих шалгуурыг хангасан аврах ажиллагаа явуулах ажилтныг томилох,
- c) Хангалттай хэмжээний стандарт шаардлага хангасан амьсгалын аппарат, аюулгүйн бүс, бэхэлгээ, нөхцөл байдалд тохирсон аврах хэрэгсэл, амилуулах багажтай байна. Эдгээр нь:
 - I. Бэлэн байдлыг хангасан;
 - II. Зохих ёсоор техник үйлчилгээ, туршилтад хамрагдсан;
 - III. Сар тутам нэг ба түүнээс олон удаа мэргэшсэн ажилтнаар шалгагдсан байна.

6.5.2 Мэргэшсэн ажилтан нь 6.5.1(с)-д заасны дагуу:

- a) Багаж хэрэгслийн бэлэн, найдвартай байдлыг шалгахдаа нягт нямбай, хариуцлагатай хандана.
- b) Шалгалт бүрийн тэмдэглэлийг хөтөлж, тайлан гаргана.

6.5.3 Хязгаарлагдмал орчны аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан нь 6.5.2 (b)-т заасан тайланд хяналт тавьж, 2 жилээс багагүй хугацаагаар архивлан хадгална.

.....оОо.....

ТӨСӨӨГ

ХЯЗГААРЛАГДМАЛ ОРЧИНД НЭВТРЭХ ЗӨВШӨӨРӨЛ

Байгууллагын нэр:		Зөвшөөрөл олгосон огноо:	__он__сар__өдөр
ХО-ны байршил:		Зөвшөөрөл дуусах огноо:	__он__сар__өдөр
ХО-ны тодорхойлолт:			
Нэвтрэх зорилго:			
Зөвшөөрөгдсөн ажилтны нэр		Зөвшөөрөгдсөн дагалдах ажилтны нэр:	
ХО-д нэвтрэсэн цаг: мин		ХО-оос гарсан цаг: мин	
АГААРЫН ЧАНАРЫН ХЭМЖИЛТ			
Үзүүлэлт	Нэвтрэхээс өмнөх дүн	Явцын хэмжилтийн дүн	
Хүчилтөрөгч (19.5-23.5%)			
Шатамхай хий LEL (<10%)			
Угаарын хий (<25 ppm)			
Хүхэрт устөрөгч (<10 ppm)			
Хорт хий 1:			
Хорт хий 2:			
Нэвтрэхээс өмнөх хэмжилт хийсэн ажилтан:	Овог нэр	Гарын үсэг	Огноо: Цаг: мин
Багажны мэдээлэл	Үйлдвэрлэгч, загвар	Сериал дугаар	Шалгалт тохируулгын огноо
			Хэмжилтээс өмнө тэг шалгалт хийсэн <input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй
ШААРДЛАГАТАЙ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ			
	Тийм	Үгүй	Тэмдэглэл
Амьсгал хамгаалах хэрэгсэл			
Хамгаалах хувцас			
Хамгаалалтын дуулга			
Хамгаалах гутал			
Нүдний хамгаалалтын шил			
Хамгаалалтын бээлий			
Бусад ХХХ			
Гал унтраагуур			
Аврах хэрэгсэл			
Түгжих, пайзлах			
Агааржуулалт			
Анхааруулах тэмдэг / хаалт			
Бусад хамгаалах арга хэмжээ:			
Агаарын чанарын явцын хэмжилт			
Холбооны хэрэгсэл			
Нэвтрэх ажилтнууд сургалтад хамрагдсан			
Нэвтэрсэн ажилтныг ажиглаж, харилцах хэлбэр	<input type="checkbox"/> Харагдах байдлаар	<input type="checkbox"/> Шууд аман харилцаа	<input type="checkbox"/> Радио холбоо <input type="checkbox"/> Телефон
Онцгой үед холбогдох утасны дугаар:			
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН:		ЗӨВШӨӨРЛИЙГ ЦУЦАЛСАН:	
Овог нэр	Гарын үсэг	Овог нэр	Гарын үсэг
ЗӨВШӨӨРЛИЙГ ХЯНАСАН:			
Овог нэр	Гарын үсэг		